

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн барилга, байгууламжийн агааржуулалтын системийн төлөвлөлт, ашиглалт байгууллага тус бүрт өөр өөр түвшинд байна.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/143 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагаатай танилцах” ажлын хэсэг 2016 оны 12 дугаар сард 21 аймагт 5 чиглэлд ажилласан. Ажлын хэсэг 8 зорилтын хүрээнд ажилласан ба 1 дүгээр зорилтын хүрээнд тухайн аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн удирдлага, инженер техникийн ажилтантай уулзаж, эмнэлгийн барилга байгууламж, цахилгаан, хийн хангамж, агааржуулалт, газардуулгын системтэй танилцаж тулгамдаж буй асуудлыг судалсан.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгад агааржуулалтын систем байхгүй эсвэл агааржуулалтын хоолой байгаа боловч ажилладаггүй, өрөө тасалгаа чийгтэй, сантехникийн шугамын алдагдлаас бохир үнэртдэг тул уг ажлын хэсгийн тайланд 66% нь хангалтгүй гэж дүгнэгдсэн.

Иймд нийслэлийн болон аймгийн төрийн өмчийн хоёр, гурав дах шатлалын эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын системийн өнөөгийн байдал, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, бодит байдлыг судлах шаардлага тулгарч байна.

Зорилго: Эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын системийн өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

Зорилт:

- Агааржуулалтын систем хариуцан ажилладаг хүний нөөцийн судалгаа хийх;
- Агааржуулалтын системийн өнөөгийн байдлыг үнэлэх;
- Агааржуулалтын системийн бүдүүвч зураглалыг баримтжуулан авах;
- Эрүүл мэндийн байгууллагад цаашид шаардлагатай агааржуулалтын системийн тооцоо хийх.

Үр дүн:

- Эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын системийн өнөөгийн бодит мэдээлэл бий болно.
- Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид бодит мэдээллээр хангагдана.
- Иж бүрэн автомат, механик, ердийн агааржуулалтын системийг ялгасан бодит мэдээлэл бий болно.
- Цаашид авах арга хэмжээ, шаардлагатай санхүүжилтийн тооцоо гарна.

ХОЁР. ЭМНЭЛГИЙН АГААРЖУУЛАЛТЫН СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Эмнэлгийн агааржуулалтын системийн өнөөгийн байдлын судалгааны арга зүй ба хамрах хүрээ

2.1.1 Судалгааны арга:

- Батлагдсан 3 бүлэг 128 асуумжийн дагуу хоёр, гурав дах шатлалын эрүүл мэндийн байгууллагаас мэдээллийг цуглуулна.
- Түүвэр хэлбэрээр Улаанбаатар хотын 4 эрүүл мэндийн байгууллагыг сонгож, тухайн эрүүл мэндийн байгууллага дээр очиж бодит байдалтай танилцан судалгааны тайланд тусгана.
- Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын системийн мэдээллийг Microsoft Office Excel програм дээр боловсруулна.

2.1.2 Судалгаанд ашиглагдах нэр томъёоны тайлбар:

- Иж бүрэн автомат агааржуулалтын систем /кондиционер/ гэж барилгын дотор орчны агаарыг халаах, хөргөх, чийгшүүлэх, бактерийг устгах гэх мэт бүрэн автомат үйл ажиллагааг хэлнэ.
- Механик агааржуулалтын систем гэж барилгын дотор агаарыг сэнсний тусламжтайгаар оруулах, соруулах ба шаардлагатай тохиолдолд цэвэрлэх, халаах үйл ажиллагааг хэлнэ.
- Ердийн агааржуулалт гэж гадна болон дотор агаарын даралтын зөрүүгээр дотор агаар гадагшлахыг хэлнэ.

2.1.3 Судалгааны хамрах хүрээ:

- Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага
- Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллага
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Аймгийн нэгдсэн эмнэлэг

2.1.4 Хугацаа:

2018 оны 08 дугаар сарын 01-нээс 8 дугаар сарын 15-ны өдөр

2.2 Мэдээлэл цуглуулах хэрэгсэл:

- Батлагдсан удирдамж болон асуумжийн дагуу төрийн өмчийн хоёр, гурав дах шатлалын эрүүл мэндийн байгууллагаас мэдээллийг цуглуулах;
- Эрүүл мэндийн байгууллагаас ирсэн мэдээллийг бүртгэж нэгтгэхэд бэлтгэх;

2.3 Мэдээлэл боловсруулах:

Судалгааны асуумжийн дагуу дүн шинжилгээ хийх ба боловсруулалтын явцад тодорхой бус мэдээллийг цахимаар болон утсаар, биечлэн очиж тодруулга хийж, тайлан бичсэн.

Асуумжийг Microsoft Office Excel программыг ашиглан үр дүнг боловсруулсан.

2.4 Судалгааны асуумж:

Батлагдсан 3 бүлэг 128 асуумжийн дагуу хоёр, гурав дах шатлалын эрүүл мэндийн байгууллагаас мэдээллийг цуглуулсан.

1.	Эрүүл мэндийн байгууллагын нэр:		
2.	Агааржуулалтын систем хариуцсан ажилтантай эсэх:	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
3.	Тийм бол ажилтны тоо		
4.	Агааржуулалтын систем хариуцсан ажилтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
5.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа хэн өгдөг вэ?	<input type="checkbox"/> Албаны дарга	<input type="checkbox"/> ХАБЭАА
6.	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх давтамж	<input type="checkbox"/> Шинэ ажилтанд	<input type="checkbox"/> 7 хоног тутам
		<input type="checkbox"/> Улирал тутам	<input type="checkbox"/> Өглөө бүр
		<input type="checkbox"/> Сар тутам	
7.	Ажлын хувцсаар байгууллага хангадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
8.	Ажлын хувцсыг шинэчилдэг хугацаа	<input type="checkbox"/> Жил тутам	<input type="checkbox"/> 1 жилээс дээш хугацаанд
		<input type="checkbox"/> Хагас жил тутам	
9.	Шаардлагатай багаж, хэрэгсэл /анеметр цахилгааны тестер, засварын багаж гэх мэт/-ээр хангадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Хангалтгүй	
10.	Шаардлагатай сэлбэг хэрэгсэл /агааржуулалтын шүүлтүүр, цахилгааны нөөц элемент/-ээр хангадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
		<input type="checkbox"/> Хангалтгүй	

2.4.1 Хүний нөөцийн мэдээлэл

1. Овог			
2. Нэр			
3. Төрсөн огноо			
4. Хүйс			
5. Одоогийн албан тушаал			
6. Хавсран гүйцэтгэх ажилтай эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
7. Хавсран гүйцэтгэж байгаа албан тушаал			
8. Харьяалагдаж байгаа тасаг нэгж			
9. Нийт ажилласан жил			
10. Тухайн байгууллагад ажилласан жил			
11. Агааржуулалтын систем хариуцан ажилласан жил			
12. Мэргэжил эзэмшсэн байдал			
Төгссөн сургууль	Мэргэжил		Төгссөн огноо
13. Боловсролын зэрэг	<input type="checkbox"/> Магистр	<input type="checkbox"/> Бакалавр	<input type="checkbox"/> Диплом
14. Агааржуулалт, салхивчийн чиглэлээр сургалтад хамрагдсан байдал (курс, магистр, доктор гэх мэт)			
Сургалтын нэр	Хаана	Хэзээ	Хугацаа
15. Цаашид агааржуулалтын системийн талаар авах сургалтын сэдэв, хэрэгцээ шаардлага :			

*Ажилтан тус бүр бөглөнө.

2.4.2 Эрүүл мэндийн байгууллагад ашиглаж байгаа агааржуулалтын системийн өнөөгийн байдал

№	Эрүүл мэндийн байгууллагын барилгын мэдээлэл	
1	Эмнэлгийн барилга, байгууламжийн блокийн тоо	
2	/Блокийн нэр эсвэл дугаар/ блок	
3	Давхрын тоо	
4	Өрөөний тоо	
5	Нийт талбайн хэмжээ	
6	/Блокийн нэр эсвэл дугаар/ блок	
7	Давхрын тоо	
8	Өрөөний тоо	
9	Нийт талбайн хэмжээ	
10	/Блокийн нэр эсвэл дугаар/ блок	
11	Давхрын тоо	
12	Өрөөний тоо	
13	Нийт талбайн хэмжээ	

*Блок тус бүрийн мэдээллийг оруулна.

*Эмнэлгийн барилга, байгууламжийн байгуулалтын зургийг хавсаргана.

№	Тасгийн нэр	Өрөөний тоо	Иж бүрэн автомат агааржуулалтын систем /концинарын/		Хэсэгчилсэн систем			Зөөврийн нэмэлт агаар цэвэршүүлэх төхөөрөмжтэй эсэх	
			Тийм /өрөөний тоо/	Үгүй	Агаарыг оруулах	Агаарыг сорох	Үгүй	Тийм /төхөөрөмжийн тоо/	Үгүй
1									
2									
3									

*Эрүүл мэндийн байгууллагын бүхий л тасаг нэгжийг судалгаанд хамруулна.

1	Эмнэлгийн хэмжээнд иж бүрэн автомат агааржуулалтын системтэй эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.1	Нийт тоо ширхэг	
1.2	Тус агааржуулалтын системээр нийт хэдэн өрөөнд агаар сэлгэлт хийдэг вэ?	
1.3	Бүдүүвч зурагтай эсэх /Тийм бол хавсралтаар ирүүлэх/	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.4	Ажиллагаа хэвийн эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.5	Засвар үйлчилгээ шаардлагатай эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.6	Засвар үйлчилгээ хийх шаардлагатай төсөв	
1.7	Урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийдэг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.8	Урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийдэг давтамж	<input type="checkbox"/> 6 сар	<input type="checkbox"/> 12 сар
		<input type="checkbox"/> 18 сар	<input type="checkbox"/> 24 сар
1.9	Урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийхдээ тэмдэглэл хөтөлж баримтжуулдаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.10	Агаарын шүүлтүүр сольдог эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
1.11	Солих хугацаа	
2	Механик агааржуулалтын систем хэд байдаг вэ?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.1	Нийт тоо ширхэг	
2.2	Тус агааржуулалтын системээр нийт хэдэн өрөөнд агаар сэлгэлт хийдэг вэ?	
2.3	Бүдүүвч зурагтай эсэх /Тийм бол хавсралтаар ирүүлэх/	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.4	Ажиллагаа хэвийн эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.5	Засвар үйлчилгээ шаардлагатай эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.6	Засвар үйлчилгээ хийх шаардлагатай төсөв	
2.7	Урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийдэг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.8	Урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийдэг давтамж	<input type="checkbox"/> 6 сар	<input type="checkbox"/> 12 сар
		<input type="checkbox"/> 18 сар	<input type="checkbox"/> 24 сар
2.9	Урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийхдээ тэмдэглэл хөтөлж баримтжуулдаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.10	Агаарын шүүлтүүр сольдог эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
2.11	Солих хугацаа	
3	Ердийн агааржуулалтын системтэй хэд байдаг вэ	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
3.1	Ажиллагааг шалгадаг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
3.2	Хэдэн сар тутамд шалгадаг эсэх	<input type="checkbox"/> 6 сар	<input type="checkbox"/> 12 сар
		<input type="checkbox"/> 18 сар	<input type="checkbox"/> 24 сар
3.3	Ердийн агааржуулалтын системтэй өрөөний агаар сэлгэлтийн дэмжиж салхивчийг нээдэг эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
3.4	Нийт хэдэн өрөөнд тогтмол агаар сэлгэлт хийдэг вэ?	
3.5	Тийм бол өдөрт хэдэн удаа салхивчийг нээдэг вэ?	
4	Зөөврийн нэмэлт агаар цэвэршүүлэх төхөөрөмжтэй эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.1	Байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа тоо /Агаар цэвэршүүлэх төхөөрөмжийн мэдээллийг дараагийн хүснэгтэд оруулах/	
4.2	Хэвийн ажиллагаатай хэд байгаа вэ?	
4.3	Засвар үйлчилгээ хийх шаардлагатай хэд байгаа вэ?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
4.4	Засварт шаардлагатай төсөв	
4.5	Ажиллагааг хэн хариуцдаг эсэх	<input type="checkbox"/> агааржуулалтын систем хариуцсан мэргэжилтэн	<input type="checkbox"/> тасгийн ахлах сувилагч
		<input type="checkbox"/> бусад /хариуцан ажиллаж байгаа мэргэжилтний нэрийг бичих/	


ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд төрийн өмчийн хоёр, гурав дах шатлалын нийт 50 эрүүл мэндийн байгууллага буюу Эрүүл мэндийн яамны харьяа 3 төв эмнэлэг, 11 тусгай мэргэжлийн төв, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа дүүргийн 7 эрүүл мэндийн төв, 2 нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар, 3 бусад эрүүл мэндийн байгууллага, 3 бүсийн оношилгоо, эмчилгээ төв, 18 аймгийн нэгдсэн эмнэлэг тус тус хамрагдсан.

3.1 АГААРЖУУЛАЛТЫН СИСТЕМ ХАРИУЦАН АЖИЛЛАДАГ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

Агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангаснаар эрүүл мэндийн байгууллагын ажиллах орчин нөхцөл сайжрах, агаар дуслын халдвараас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ. Иймд эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилладаг хүний нөөцийн мэдээлэл чухал юм. Судалгаанд хамрагдсан нийт 50 эрүүл мэндийн байгууллагын 24 нь агааржуулалтын систем хариуцсан ажилтантай, 27 нь хариуцсан ажилтангүй байна. Эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын систем хариуцан ажилладаг хүний нөөцийн өнөөгийн байдлыг Дүрслэл.1-д харуулав.

Дүрслэл 1. Эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын систем хариуцан ажилладаг хүний нөөцийн өнөөгийн байдал



Агааржуулалт хариуцсан ажилтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг 23 байгууллага өгдөг ба үүнээс 11 албаны дарга, 12 хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан зааварчилгаа өгдөг байна. Үүнээс өглөө бүр 5, долоо хоног тутам 6, сар тутам 5, улирал бүр 4, шинэ ажилтанд 4 байгууллага зааварчилгаа өгч ажиллаж байна.

Агааржуулалт систем хариуцсан ажилтан эмнэлгийн барилгын дотор, гадна ажилладаг тул ажлын хувцсыг тогтмол сольж өмсөх шаардлага гардаг. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.2.5 дугаар зүйлд “ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх” гэж заасан байдаг. Нийт 22 байгууллага агааржуулалтын систем хариуцсан ажилтанг ажлын хувцсаар хангадаг бөгөөд үүнээс хагас жилд 1, нэг жилд 14, нэг жилээс дээш хугацаанд 7 байгууллага ажлын хувцсыг шинэчилдэг.

Агааржуулалтын систем хариуцсан ажилтанг шаардлагатай багаж хэрэгслээр бүрэн хангадаг 13, бүрэн бус хангадаг 8, огт хангадаггүй 2 байгууллага байна. Харин агааржуулалтын хэвийн ажиллагааг ханган ажиллах зорилгоор шаардлагатай сэлбэг хэрэгслээр бүрэн 15, дутагдалтай 2, огт хангадаггүй 5 байгууллага байна.

Шигтгээ.1: Манай агааржуулалтын системд 2017 онд эвдрэл гэмтэл гарсан. Холбогдох санхүүгийн тооцоо, зардлыг гарган байгууллагын удирдлагад танилцуулсан боловч хөрөнгө мөнгө байхгүй гэдэг шалтгаанаар өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй байна.

Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл

Нийт 24 эрүүл мэндийн байгууллагад 30 агааржуулалтын систем хариуцсан ажилтан ажиллаж байгаа ба төгссөн мэргэжлээр нь ангилвал агааржуулалт, салхивч дулааны инженер 6, салхивч, агааржуулалтын техникч засварчин 5, цахилгааны инженер 6, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер 7, аж ахуйн менежер 6 байна. Үүнээс агааржуулалтын систем хариуцсан ажилтны 13 нь өөр ажил хавсран гүйцэтгэж байна. Мөн нийт ажилчдын 24 буюу 80% нь таван жил хүртэл, түүнээс дээш жил ажилласан 6 ажилтан байна.

Шигтгээ.2: Би агааржуулалтын систем болон сантехникийн техникч хавсран гүйцэтгэдэг. Сантехникийн өдөр тутмын ажил их байдаг тул агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах ажил үргэлж орхигддог.

Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл

Шигтгээ.3: Эрүүл мэндийн төв нь 1987 онд ашиглалтад орсон. Агааржуулалтын систем хийгдсэн боловч ажиллуулж үзээгүй, тоног төхөөрөмж нь дутуу байгаа тул холбогдох санхүүжилтийг шийдвэрлэн мэргэжлийн хүн ажиллах шаардлагатай байна.

Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв

Агааржуулалт, салхивчийн чиглэлээр 3 ажилтан сургалтад хамрагдсан бөгөөд агааржуулалтын систем хариуцсан ажилчдын 23 нь орчин үеийн эмнэлгийн барилгын агааржуулалтын системийн ажиллагааны горим, техник үзүүлэлтийн талаар сургалтад хамрагдах хүсэлтэй байна.

Бүлгийн дүгнэлт: Эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн агааржуулалтын систем хариуцан ажилладаг ажилтны тоо хангалтгүй байгаа бөгөөд нийт хариуцсан ажилчдын 43% өөр ажил хавсран гүйцэтгэж байна. Ажлын ачаалал ихээс хамаарч агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагааг хянах, хангах ажлуудыг орхигдуулж байна. Иймээс ажлын ачааллыг тооцож, ажлын байрны тодорхойлолтод тогтмол хийх ёстой үйл ажиллагааг нарийн тусгах шаардлагатай байна.

Мөн агааржуулалтын систем хариуцан ажилтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх, холбогдох ажлын хувцас, багаж, сэлбэг хэрэгслээр ханган дэмжлэг үзүүлэх, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, тэднийг чадавхижуулах хэрэгцээ шаардлага их байна.


3.2 АГААРЖУУЛАЛТЫН СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан 50 эрүүл мэндийн байгууллагын 236 эмнэлгийн барилгын 16,819 өрөө тасалгаатай байна. Үүнээс:


Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд иж бүрэн автомат агааржуулалтын системтэй 7, агаарын хэсэгчилсэн системтэй 11, зөөврийн нэмэлт агаар цэвэршүүлэгч ашигладаг 11 эрүүл мэндийн байгууллага байна.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд иж бүрэн автомат агааржуулалтын системтэй 5, агаарын хэсэгчилсэн системтэй 6, зөөврийн нэмэлт агаар цэвэршүүлэгч ашигладаг 11 эрүүл мэндийн байгууллага байна.

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын иж бүрэн автомат агааржуулалтын системтэй 8, агаарын хэсэгчилсэн системтэй 11, зөөврийн нэмэлт агаар цэвэршүүлэгч ашигладаг 4 эрүүл мэндийн байгууллага байна.


Дүрслэл 2. Эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын системтэй өрөө, тасалгааг ангилан харуулсан байдал

Нийт 20 эрүүл мэндийн байгууллагын 69 иж бүрэн агааржуулалтын системээр нийт 1163 өрөө тасалгаанд агаарын сэлгэлт хийдэг. Үүнээс агааржуулалтын системийн бүдүүвч зурагтай 9 эрүүл мэндийн байгууллага байна.

Дүрслэл 3. Иж бүрэн агааржуулалтын системтэй байгууллага

Иж бүрэн агааржуулалтын системийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг тогтмол 14 байгууллага хийдэг. Үүнээс 13 байгууллага зургаан сар тутамд үзлэг, үйлчилгээ хийж, 10 байгууллага үзлэг, үйлчилгээний тэмдэглэл хөтөлж байна. Агааржуулалтын шүүлтүүрийг гурван сар тутамд 1, зургаан сар тутамд 7, арван найман сар тутамд 1 байгууллага сольдог байна. Мөн 11 эрүүл мэндийн байгууллагын агааржуулалтын системд засвар үйлчилгээ хийх хэрэгтэй ба засварын зардалд нийт 312,0 сая төгрөг шаардлагатай байна.


Харин 28 эрүүл мэндийн байгууллагын 302 хэсэгчилсэн агааржуулалтын системээр 1499 өрөө тасалгаанд агаарын сэлгэлт хийдэг. Үүнээс агааржуулалтын системийн бүдүүвч зурагтай 12 эрүүл мэндийн байгууллага байна.

Дүрслэл 4. Хэсэгчилсэн агааржуулалтын системтэй байгууллага

Хэсэгчилсэн агааржуулалтын системийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг тогтмол 23 байгууллага хийдэг. Үүнээс 19 байгууллага зургаан сар сар тутамд, үзлэг, үйлчилгээ хийж, 14 байгууллага үзлэг, үйлчилгээний тэмдэглэл хөтөлж байна. Агааржуулалтын шүүлтүүрийг тогтмол сольдог 12 байгууллага байгаагаас нэг сар тутамд 2, зургаан сар тутамд 2, нэг жилд тутамд 5, гэмтсэн тохиолдолд 1 байгууллага сольдог байна. 18 эрүүл мэндийн байгууллагын хэсэгчлэсэн агааржуулалтын системд засвар үйлчилгээ хийх хэрэгтэй ба засварын зардал нийт 63,8 сая төгрөг шаардлагатай байна.

Ердийн агааржуулалтын системтэй 34 эрүүл мэндийн байгууллага байдаг. Үүнээс 30 байгууллага нь агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг шалгадаг ба зургаан сар тутамд 22, нэг жилд тутамд 6, хоёр жил тутамд 1 гэсэн давтамжтай байдаг.

Ердийн агааржуулалтын системтэй өрөөний хувьд салхивчийг тогтмол хугацаанд онгойлгож агаар сэлэлтийг хийх ёстой байдаг ч 24 байгууллага нь өдөр 1-5 удаа агаар сэлэлтийг хийдэг байна.

Дүрслэл 5. Ердийн агааржуулалтын системтэй байгууллага

Нийт 26 эрүүл мэндийн байгууллага нийт 923 зөөврийн нэмэлт агаар цэвэршүүлэх төхөөрөмж ашигладаг. Үүний 30% буюу 305 агаар цэвэршүүлэх төхөөрөмжийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд ашиглаж байна. Дээрх агаар цэвэршүүлэх төхөөрөмж ашигладаг эрүүл мэндийн байгууллагын агааржуулалт хариуцсан ажилтан 3, тухайн тасгийн ажилтан 11, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер 3 тус тус хэвийн ажиллагааг ханган хяналт тавин ажилладаг ба урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг тогтмол 19 байгууллага байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ: Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын 28 буюу 40% нь иж бүрэн, 28 буюу 56% хэсэгчилсэн, 34 буюу 68% нь ердийн агааржуулалтын системтэй байна. Иж бүрэн болон хэсэгчилсэн агааржуулалтын системийн нийт байгууллагын 21 нь буюу 43,7% бүдүүвч зурагтай, 37 нь буюу 77% нь агааржуулалтын системд урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг тогтмол хийж байгаа ч 14 буюу 50% байгууллагын ажилтан урьдчилсан сэргийлэх үзлэгийн тэмдэглэл хөтөлж байна. Иймд эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа агааржуулалтын систем хангалтгүй, мөн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг тогтмол хугацаанд хийж гүйцэтгэх, холбогдох засварын зардлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Ердийн агааржуулалтын системтэй байгууллагын 24 нь буюу 70% хувь салхивчийг тогтмол хугацаанд онгойлгож агаар сэлэлт хийдэг гэж мэдээлсэн боловч өвлийн улиралд болон төрсөн эх, нярай байрлах өрөө, тасалгаанд агаар сэлгэлт огт хийгддэггүй тул агаар сэлгэлт хийж шийдлийг олж холбогдох стандартад тусгах шаардлагатай.


Мөн зөөврийн нэмэлт агаар цэвэршүүлэх төхөөрөмжийн ашиглалт их байгаа түүнийг хариуцан ажилладаг ажилтны 82,3% мэргэжлийн бус ажилтан байна. Мэргэжлийн бус ажилтнаар агаар цэвэршүүлэх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах хариуцуулснаар цэвэршүүлэх төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах, насжилт богиносгох зэрэг асуудал үүсч болзолшгүй. Иймд агааржуулалтын систем хариуцсан ажилтанд агаар цэвэршүүлэх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах ажлыг хариуцуулах хэрэгтэй.

Мөн агааржуулалтын шүүлтүүрийн ач холбогдлыг мэдэхгүй болон санхүү мөнгө хангалтгүй байгаагаас иж бүрэн болон хэсэгчилсэн агааржуулалтын системийн нийт байгууллагын 25 буюу 52% нь агаарын шүүлтүүрийг тогтмол хугацаанд сольж байна. Агаар шүүлтүүрийг тогтмол хугацаанд сольж хэвшүүлэх, ингэснээр тасалгааны агаарын чанар сайжирч, агаар дуслын халдвараас урьдчилан сэргийлэх боломжтой.


3.3 АГААРЖУУЛАЛТЫН СИСТЕМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Эмнэлгийн агааржуулалтын системтэй болох шаардлагатай хоёр, гурав дах шатлалын 44 эрүүл мэндийн байгууллагын 310 тасаг нэгжийн 6033 өрөө тасалгаанд 546 иж бүрэн, 216 хэсэгчилсэн, 253 ердийн агааржуулалтын систем байна. Мөн 38 эрүүл мэндийн байгууллагын 291 тасаг нэгжид нийт 1498 ширхэг агаар цэвэршүүлэх төхөөрөмж шаардлагатай байна. Агааржуулалтын систем болон агаар цэвэршүүлэх төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг нэгтгэн дүрслэл. 6.7-д харуулав.

Дүрслэл 6. Эрүүл мэндийн байгууллагад шаардлага агааржуулалтын системийн хэрэгцээ шаардлага /тоо ширхгээр/



Дүрслэл 7. Эрүүл мэндийн байгууллагад шаардлага агаар цэвэршүүлэх төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага /тоо ширхгээр/



Судалгаанд хамрагдсан 50 эрүүл мэндийн байгууллагын 44 цаашид нэмэлтээр агааржуулалтын систем болох хэрэгцээ байгаа бөгөөд түүнд нийт 6 тэрбум төгрөгийн төсөв шаардлагатай байна. Харин агаар цэвэршүүлэх шаардлагатай 38 эрүүл мэндийн байгууллага байгаа бөгөөд үүнд 1,9 тэрбум төгрөг шаардлагатай байна.

Бүлгийн дүгнэлт: Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын 88% нь агааржуулалтын системтэй, 76% нь агаар цэвэршүүлэх төхөөрөмжтэй шаардлагатай байгаа нь эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа агааржуулалтын нэгдсэн систем хангалтгүй байгаа нь харагдаж байна.

3.4 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ТҮҮВЭР БАЙДЛААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТАЙЛАН

Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа агааржуулалтын системийн судалгааг хийхдээ түүвэр байдлаар Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн Амгалан амаржих газар гэсэн Улаанбаатар хотын 4 эрүүл мэндийн байгууллагыг сонгосон. Түүвэр байдлаар судалгааг хийхдээ 2018 оны 8 сарын 7-ноос 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн ба Нийслэлийн Өргөө амаржих газрын Салхивчийн инженер Д.Уранбилэгтэй хамтран ажилласан.

Хэмжилт хийхдээ агаарын урсгалын хэмжигч; тасалгааны CO2 хэмжигч; хорт бодисын хэмжээг хэмжигч гэсэн хэмжилтийн тоног төхөөрөмжүүдийг ашигласан бөгөөд хэмжилтийн тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт.1-ээс харна уу.

Хүснэгт 1. Хэмжилтийн тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Хэмжилтийн тоног төхөөрөмжийн нэр	Марк модель	Хэмжих үзүүлэлт
1	Агаарын урсгалын хэмжигч	UNIT UT363	- Агаарын урсгал хурд - Температур
2	Тасалгааны CO2 хэмжигч	НТ-2000	- CO2 хэмжээ - Температур - Агаарын харьцангуй чийгшил
3	Хорт бодисын хэмжээг хэмжигч		- Агаарт байгаа хорт бодисын хэмжээ - Температур - PM2.5-ийн хэмжээ - Агаарын харьцангуй чийгшил

3.5.1 Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Улсын нэгдүгээр төв эмнэлэг дээр 2018 оны 8 сарын 9-ний өдөр ажилласан. Тус эмнэлэг нь 4 блок 630 өрөө буюу нийт 20840 м² талбайтай барилгатай. Үүнээс нэгдсэн лаборатори, ариутгал, хагалгаа, эрчимт эмчилгээ, мэдрэлийн тасгуудын агааржуулалтын системтэй танилцаж, хэмжилт хийсэн.

Эрчимт эмчилгээний тасаг нь агааржуулалтын систем огт байхгүй байсан бөгөөд эмчилгээний зааланд агаар цэвэршүүлэх төхөөрөмжийг ашигладаг.

Нэгдсэн лабораторийн тасаг нь анх барилга баригдахад хийгдсэн механик агааржуулалтын системтэй боловч ажилладаггүй буюу агааржуулалтын сетк хаалттай. Өрөөнд ороход лабораторийн тоног төхөөрөмжийн урвалжийн үнэр ихээр үнэртэж байсан бөгөөд цэвэр орчинд лабораторийн шинжилгээ хийх шаардлагатай байдаг тул цонх онгойлгодоггүй.

Шигтгээ 5: Лабораторийн ажилчид тус тасгийн өрөөнүүд их бүгчим халуун, урвалжийн үнэр байна үнэртдэг гэж байсан. 2018 оны 8 сарын 20-ны өдрөөс эхлэн тус лабораторийн хэсгийг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр шинэчлэн засвар хийгдэхээр төлөвлөгдсөн тул бид агааржуулалтын талаар мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах шаардлагатай байна гэдгийн дурдаж байсан.

Лабораторийн ажилчдын төлөөлөл

Ариутгалын тасгийн механик агааржуулалтын системийг БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар 2015 оны 9 дүгээр сард хийсэн. Угаах, хатаах, автоклавны, цэврийн өрөөнүүдэд суурилуулсан механик агааржуулалтын системд хэмжилт хийхэд агаар оруулах, соруулах хэсгийн ажиллагаа хангалтгүй байсан бөгөөд сорох хэсгийг буруу хийснээс хаалт бүрэн нээгдэхгүй байсан. Тус хэсгийн агааржуулалтыг хариуцан ажиллаж эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерт хэвийн ажиллагаанд оруулах заавар зөвлөгөө өгч ажилласан.

Амбулаторийн 13 тоот рентген аппаратын өрөөнд механик агааржуулалтын системийг сүүлд нэмэлтээр төлөвлөсөн бөгөөд агаар оруулах, соруулах хэсэг хэвийн ажиллагаатай байсан. Харин бусад рентген өрөөний агааржуулалт ажиллахгүй байсан.

3.5.2 Халдварт өвчин судлалын үндэсний төв

Халдварт өвчин судлалын үндэсний төв дээр 2018 оны 8 сарын 8-ны өдөр ажилласан. Тус төв нь 28 блок 1504 өрөө буюу нийт 58485 м² талбайтай барилгатай бөгөөд анх тус барилгуудыг барихдаа эмнэлгийн халаалтыг 60% нь радиатороор, 40% нь агааржуулалтын систем буюу салхивчаар өгөхөөр шийдсэн боловч өвлийн улиралд хүйтнээр үлээдэг ба цахилгаан зарцуулалт их байдаг. Мөн өнөөдрийн байдлаар анх төлөвлөсөн агааржуулалтын системийн 50 - 60% ажиллагаагүй болж тоногдсон.

Сүрьеэгийн 5 давхрын механик агааржуулалтын системийн гадна агаар сорох хэсэгт сүүлд засвар хийх ажилчдыг байрлуулснаар агаарын солилцоог хангалттай хийж чаддаггүй. Гадна агаар соруулах хэсгийг гадагш гарахад шаардлагатай төсөв мөнгө байдаггүй.

Зураг.1 ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тасгийн 5 давхрын гадна агаар сорох хэсэг ердийн тасалгаанд байрлаж байгааг харуулсан зураг



Сүрьеэгийн тасгийн 5, 6 давхрын агааржуулалтын хариуцсан ажилтан байдаггүй ба автоматаар асч, унтрах горимоор ажилладаг. 5 давхарын агааржуулалтын системийн кварц огт ажилладаггүй ба солих мөнгө төсөв байхгүй. Тус давхаруудад эм дасалтай буюу хүнд хэлбэрийн сүрьеэтэй үйлчлүүлэгч нар 6 сараас дээш хугацаагаар хэвтэн эмчлүүлдэг. Гэвч тус давхаруудын үйлчлүүлэгчдийн өрөө тус бүр механик агааржуулалтын нэгдсэн системтэй боловч агаар өгөх, соруулах хэсгүүд ажилладаггүй. Тус агааржуулалтын системийн шүүлтүүр жил бүр сольдог байсан ч сүүлийн 1 жил огт солиогүй. Хариуцсан ажилтан, тасгийн эмч сувилагч нар агааржуулалтын системийн талаар мэдээлэл хомс байсан.

Шигтгээ 6: Сүрьеэгийн тасгийн 5, 6 давхарт ажилладаг эмч сувилагч нар сүрьеэгийн халдварт авч байсан нь агааржуулалтын системийн ажиллагаатай холбоотой гэж боддог.

ХӨСҮТ-ийн ажилчдын төлөөлөл

Нян бактерийн лабораторийн механик агааржуулалтын системийг “Глобаль сан”-гийн санхүүжилтээр “ВТ” ХХК 2010 онд хийсэн. Хэмжилт хийх үед агааржуулалтын системийн ажиллагаа хангалтгүй байсан ба агааржуулалтын хяналтын системийн салбар дээр алдаа заасан боловч засуулаагүй удсан байсан тул хариуцсан ажилтанд засварын дуудлага өгсөн.

Бэлгийн замын халдварын лаборатори нь агааржуулалтын системгүй тул өрөөнүүдэд их халуун байдаг. Тус лабораторийн молекул биологийн өрөөнд тоосжилттой орчинд шинжилгээ хийж болохгүй тул ердийн агааржуулалтын системийг хаасан. Мөн тус өрөө нь 3.6м*2.7м*3.5м хэмжээтэй бөгөөд ихэнх талбайд лабораторийн тоног төхөөрөмжүүдийг байрлуулсан тул өрөөнд 1 ажилтан /2 ажилтан ажиллах ёстой/ ажилладаг ба лабораторийн өрөөнд ажиллахад лабораторийн урвалж их үнэртдэг. Тэжээлийн өрөөнд лабораторийн 80°C, 50°C-ийн 2 усан банныг ажиллуулах үед маш халуун байдаг талаар ажилчид ярьж байсан.

3.5.3 Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг

Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг дээр 2018 оны 8 сарын 10-ны өдөр ажилласан. Эмнэлэг нь 3 блок, 199 өрөө тасалгаатай буюу нийт 4910,68 м² талбайтай.

Тус эмнэлэг дээр ажиллах үеэр хагалгааны туршид хэмжилт хийх боломж олдсон тул 1 цаг 40 минутын хугацаанд 10 минутын давтамжтайгаар хэмжилт хийсэн. Хагалгааны өрөөний хэмжээ нь 6м*3.5м*3м байсан бөгөөд нийт 7 хүн ажиллаж байсан. Хагалгааны эхлэхэд агаарын нүүрстөрөгчийн хэмжээ 1027 байсан бол 40 минутын дараа 2 дахин нүүрстөрөгчийн хэмжээ ихэсч хүнийг унтаа байдал оруулах

түвшинд хүрч хэмжигч багажны дуут дохио дуугарч эхэлсэн. Харин хагалгааны дуусахад нүүрстөрөгчийн хэмжээ 2541 болтлоо нэмэгдэж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрсэн.

3.5.4 Нийслэлийн Амгалан амаржих газар

Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг дээр 2018 оны 8 сарын 07-ны өдөр ажилласан. Эмнэлэг нь 2 блок, 276 өрөө тасалгаатай буюу нийт 9144,6м² талбайтай.

Тус амаржих газрын хагалгаа, ариутгал, лаборатори, хэвтэн эмчлүүлэх гэсэн 4 тасагт ажилласан. Амаржих газрын барилга 2016 онд ашиглалтад орсон бөгөөд хагалгааны өрөөг бүрэн автомат бусад өрөөг ердийн агааржуулалтын системтэй байхаар төлөвлөсөн.

Хагалгааны 4 өрөөтэй бөгөөд өрөө бүр агааржуулалтын нэгдсэн удирдлагын самбартай байсан хэдий ч агааржуулалтын ажиллагааг шалгахад агаар өгөх хэсэг ажиллахгүй, агаар соруулах хэсэг ажиллаж байсан. Агаар өгөх хэсэг ажиллахгүй байгаа талаар тодруулахад ажилчид нь мэдэхгүй байна.

Тус амаржих газрын ариутгалын тасгийн анх барилгын зураг хийхдээ төлөвлөж байснаас өөр газар одоо байрлаж байгаа тул автоклавын өрөө агааржуулалтын системгүй байсан. Ажилчдаас асууж тодруулахад автоклав ажиллуулж байх үед маш их халуун байдаг тул ажиллахад хүндрэлтэй байдаг талаар дурдаж байсан. Бид хагалгаагүй өдөр тухайн амаржих газарт ажилласан тул өрөө харьцангуй сэрүүн байсан.

Лабораторийн тасаг нийт 14 өрөөтэй бөгөөд түүнээс 6 нь ердийн агааржуулалтын системтэй боловч лабораторид тавигдах шаардлагын дагуу 3 агааржуулалтын сеткийг хаасан байсан. Харин хэвтэн эмчлүүлэх тасаг нийт 18 өрөөнөөс агааржуулалтыг сетктэй 9 өрөө байсан боловч 4 сеткийг цаасаар хаасан байсан. Хариуцсан ажилтнаас асуухад өвлийн улиралд хүйтнээр үлээдэг тул байгууллагын ихэнхи өрөөний агааржуулалт сетийг цаасаар хаадаг талаар дурьдаж байсан. Өвлийн улиралд агааржуулалтын сетк хүйтнээр үлээх нь агааржуулалтын системийн буруу төлөвлөлт болон дулаалга огт хийгээгүй болдог. Иймээс дээврийн давхарт гарч агааржуулалтын хэсгийг шалгахад өвлийн улиралд хийсэн дулаалгын зармыг аваагүй байсан. Энэ нь зуны улиралд өрөө тасалгаанд агаар сэлгэлт хийх боломж нөхцөлийг бүрэн хааж байсан.

Зураг.2 Ердийн агааржуулалтын системийн хоолой



Эрүүл мэндийн байгууллагын өрөө, тасалгааны агааржуулалтын агаарын чанарын хэмжилтийг нэгтгэн хүснэгт 2-д харуулав.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн байгууллагын агаарын чанарын харьцуулалт

№	Хэмжилтийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Байх ёстой хэмжээ	Хамгийн их утга	Хамгийн бага утга	Дундаж утга
1	Температур	С ⁰	18-20	29.8	22	26.5
2	Агаар сорох урсгалын хурд	м/сек	2.0-2.5	4.2	0.0	2.1
3	Агаар өгөх урсгалын хурд	м/сек	2.0-2.5	4.4	0	2.2
4	Нүүрстөрөгчийн хэмжээ		<700	2541	428	910.7
5	Харьцангуй чийгшил	%	55-60	74.5	53.5	33.5
6	Хорт бодисын хэмжээ	мг/м ³	<0.1	3.044	0	1.027
7	PM2.5-ийн хэмжээ	µг/ м ³	<75	97	1	18.7

Хэмжилт үзүүлэлтийн байх ёстой хэмжээг MNS 6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” болон олон улсын судалгааны баримт бичгээс авсан болно.

Хэмжилт хийсэн 2018 оны 8 сарын 7-ноос 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод бороотой, 27-30⁰С-ын дулаантай байсан.

Дээр хэмжилт хийсэн үзүүлэлтээс харахад агаарын чанарын үзүүлэлтүүд байх ёстой хэмжээнээс их байгааг харж болно. Хүний ажиллахад таатай өрөөний температурын хэмжээ нь 18-20⁰С байхад хэмжилт хийсэн өрөөнүүдийн дундаж температур 26.5⁰С байна. Иймд температуртай орчинд ажиллахад хүний нойр хүрэх, залхуурах шинж тэмдэг илэрдэг байна.

Нүүрстөрөгчийн болон хорт бодис, PM2.5-ийн хэмжээ байх ёстой хэмжээнээс харьцангуй их буюу хүний биед сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрч байна.

Бүлгийн дүгнэлт: Түүвэр байдлаар судалгаанд хамрагдсан 4 байгууллага дээр ажиллахад агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах, түүний ач холбогдол, ажиллагааны талаарх мэдээлэл ажилчдад хомс байгаа нь харагдаж байсан. Иймд агааржуулалт хариуцсан ажилтанг чадавхижуулах, байгууллагын удирдлага болон ажилчид агааржуулалтын ажиллагаа болон ач холбогдлын талаар мэдээлэл өгөх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол орон нь өвлийн улиралд хүйтэн, утаа их байдаг тул агаарын чанарын судалгааг өвлийн улиралд тодорхой давтамжийн дагуу хийж танилцуулах, холбогдох стандартыг сайжруулах, агааржуулалтын системийн төлөвлөлт, хийж гүйцэтгэж байгаа байгууллагад хяналт тавих шаардлага тулгарч байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд төрийн өмчийн хоёр, гурав дах шатлалын нийт 50 эрүүл мэндийн байгууллагад буюу Эрүүл мэндийн яамны харьяа 3 төв эмнэлэг, 11 тусгай мэргэжлийн төв, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа дүүргийн 7 эрүүл мэндийн төв, 2 нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар, 3 бусад, 3 бүсийн оношилгоо, эмчилгээ төв, 18 аймгийн нэгдсэн эмнэлэг тус тус хамрагдсан.

Судалгааны үр дүнг харахад эмнэлгийн агааржуулалтын систем хариуцан ажилладаг ажилчдын тоо хангалтгүй ба ажил үүргийн хуваарь тодорхой биш байна. Иймд ажил үүргийн хуваарийг тодорхой болж, хариуцсан ажилчдыг чадавхижуулах хэрэгцээ шаардлага их байна.

Түүвэр байдлаар нийслэлийн 4 байгууллага дээр ажиллахад агааржуулалтын системтэй боловч түүний хэвийн ажиллагааг тогтмол ханган урьдчилсан үзлэг, үйлчилгээг тогтмол хийж чадахгүй байгаа нь харж байсан.

Халдвартай үйлчлүүлэгч хүлээн авдаг тасаг нэгжүүдэд иж бүрэн агааржуулалтын системийг цогцоор шийдвэрлэж эрүүл мэндийн байгууллагын ажилчдын эрүүл, таатай ажиллах, агаар дуслын халдвараас урьдчилсан сэргийлэх нөхцөл бололцоог бүрдүүлж шаардлага тулгарч байна.

Өнөөдөр лаборатори, хагалгааны тасаг ажиллаж байгаа эмч, сувилагч нар эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд хүрсэн орчинд ажлаа хийж гүйцэтгэж байгаа хэмжилтийн үр дүнгээс харж болно. Цаашид хагалгаа, ариутгал, лаборатори, төрөх, хүүхдийн хэвтэн эмчлүүлэх гэх мэт онцлог тасаг нэгжүүдийн агааржуулалтын системийг шинэчлэх, норм дүрмийг тодорхойлон боловсруулах шаардлагатай байна. Мөн эрүүл мэндийн байгууллагын ажилчдад агааржуулалтын системийн талаар мэдээлэл, сургалт явуулж хэвийн үйл ажиллагааг хангах боломж нөхцөлийг бүрдэх шаардлагатай тулгарч байгаа нь судалгаанд явцад илэрсэн.

Мөн агааржуулалтын системийн төлөвлөлт болон гүйцэтгэл хангалтгүй байгаагаас үүдэж өвлийн улиралд хүйтэн агаар өрөө тасалгаанд орж ирэх асуудлууд үүсч байна. Иймээс агааржуулалтын системийн төлөвлөлтийг зөв хийж гүйцэтгэх, түүнийд хяналт тавих системийг бүрдүүлэх хэрэгтэй.